

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН 2024 ОНЫ 6 САРЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ТАЙЛАН

2024 оны 06 дүгээр сарын 10

Мандалговь хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, үндэслэл, арга зүй

Монгол Улсын хууль, Улсын их хурлын тогтоол, Улсын их хурлын байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн Газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгавар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөмжийн хуралдааны тэмдэглэл зэрэг шийдвэрийн заалтуудыг хяналтад авахуулан эзэнжүүлж, хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ, үнэлгээг тасралтгүй хийж үр дүнг үнэлэх, дүгнэлт гаргах, цаашид шийдвэр гаргах түвшинд арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэн хэрэгжилтийн бодит үр дүнг нэмэгдүүлэхэд оршино.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг үнэлэхдээ тайлан, мэдээлэл ирүүлсэн үйл явц, үр дүнг нотолж буй баримтад тулгуурлан хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.3-д заасан үнэлгээ өгөх аргачлалын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж гүйцэтгэлээ.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

2024 оны хагас жилийн байдлаар Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сан /unelgee.gov.mn/-д байршуулсан 123 шийдвэр: Монгол улсын хууль-7, Улсын их хурлын тогтоол -7, Улсын их хурлын байнгын хорооны тогтоол-16, Ерөнхийлөгчийн зарлиг -5 Засгийн газрын тогтоол-43, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл-38, Засгийн газрын албан даалгавар-1 Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж -6 нийт 203 заалтын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж 89.84 хувиар үнэлэв.

Хэрэгжилтийн үнэлгээний үе шат тус бүрээр нь авч үзвэл:

- Бүрэн хэрэгжсэн 141 заалт нь нийт заалтын 74 хувийг
- Хэрэгжих шатандаа байгаа 39 заалт нь 21 хувийг
- Хэрэгжилт хангалтгүй хэрэгжсэн 11 заалт нь 0,6 хувийг
- Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй 12 заалт 0.7 хувийг эзэлж байна.

Дундговь аймагт хэрэгжиж байгаа хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн жагсаалт болон хэрэгжилтийн явцыг Dundgovi.gov.mn сайт, төрийн байгууллагын цахим программ болох egr.e-mongolia.mn программын файлын сан хэсэгт байршуулан мэдээллээр ханган ажиллаж байна. Мөн явцын хяналт шинжилгээгээр

төрийн байгууллагуудыг мэдээллээр хангаж, хэрэгжилтийн явцад тогтмол хяналт тавин ажиллаж байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээс харахад Улсын их хурлын байнгын хорооны тогтоол 96.67 хувьтай буюу үр дүнтэй хэрэгжсэн байна. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгаврын дундаж 78,45 хувийн хэрэгжилттэй байгаа нь урт хугацааны туршид хэрэгжих болон зохион байгуулалтаас шалтгаалан хэрэгжих шатандаа байна.

Аймгийн хэмжээнд хэрэгжиж байгаа Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн жагсаалтыг гарган Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 24 агентлагт хүргүүлэн хяналтанд авахуулан сургалт зөвлөгөө, түгээн дэлгэрүүлэлтийн ажлыг зохион байгуулан зөвлөн тусалж ажиллалаа.

Гурав. Дүгнэлт

Аймгийн хэмжээнд 2024 оны эхний хагас жилийн байдлаар хэрэгжиж буй холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд 89.84 хувьтай байна. Удаашралтай хэрэгжиж байгаа Засгийн газрын тогтоол 4, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл-7 нийт 11 заалтын хэрэгжилтийг авч үзвэл Санхүүжилтээс шалтгаалсан-1, Урт хугацааны туршид хэрэгжих-2, Зохион байгуулалтаас шалтгаалсан-8 заалт байна. Мөн хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй нийт 11 заалтыг хяналтадаа авч хэрэгжилтийн бодит үр нөлөөг нэмэгдүүлэх тал дээр анхаарч ажиллах шаардлагатай байна.

Холбогдох хэлтэс, агентлагт хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй болон удаашралтай хэрэгжиж байгаа заалтуудын шалтгаан нөхцөлийг тодруулан зохион байгуулалтаас шалтгаалсан заалтуудыг эрчимжүүлэх, санхүүжилт төсөв хөрөнгөтэй холбоотой заалтуудыг 2025 оны орон нутгийн төсөвт суулгах, дараа оны байгууллагын төлөвлөлтөд тусган хэрэгжүүлж ажиллахыг холбогдох хэлтэс, агентлагт зөвлөмж өгч ажиллалаа.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хяналтад авч, удаашралтай хэрэгжиж буй хууль тогтоомж, тогтоолын шийдвэрийн шалтгаан нөхцөлийг судлан дүгнэлт хийж хэрэгжилтийн бодит үр дүнг нэмэгдүүлэх, төрийн байгууллагуудын хамтын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор сургалт зөвлөгөө өгч ажлын гүйцэтгэлийн үр дүнгээрээ тэргүүлсэн байгууллагаас туршлага судлан түгээн дэлгэрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан нь хэрэгжилтийг чанартай тайлагнахад ахиц дэвшил гарч байна.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн үр дүнг unelgee.gov.mn цахим программд байршуулахдаа шийдвэрийн заалт бүрийн ард хэрэгжиж дууссан, нэг удаагийн шинжтэй, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон шийдвэрийн заалт бүрийг нэг бүрчлэн хянаж 31 заалтыг хяналтаас хасуулах тэмдэглэгээг хийсэн.

Дөрөв. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ / Зөвлөмж /

1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг гаргахдаа үйл явцыг бус үр дүн, үр нөлөөг тодруулан бичиж нотлох баримтыг хавсаргаж хэвших
2. Шинээр гарч буй хууль тогтоомж, тогтоол шийдвэрүүдийг сурталчлах, иргэдэд мэдээлэх ажлыг эрчимжүүлэн ажиллах.

ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС